

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2015 оны 3 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах улсын албадыг
шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16.2, 17.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гамшгаас хамгаалах улсын албад, тэдгээрийн түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага, албадын дарга нарыг хавсралт ёсоор баталсугай.

2. Гамшгаас хамгаалах улсын албадын бүрэлдэхүүнийг томилж, тэдний гүйцэтгэх үүргийг тогтоож, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг улсын албадын дарга нарт, улсын албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхэд тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулах тухай” Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 186 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Монгол Улсын Шадар сайд

У.ХҮРЭЛСҮХ

Засгийн газрын 2015 оны 81 дүгээр
тогтоолын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАД

№	Улсын албадын нэр	Түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага	Улсын албаны дарга
1	Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд
2	Барилга, хот байгуулалтын алба	Барилга хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Барилга, хот байгуулалтын сайд
3	Зам, тээврийн алба	Зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Зам, тээврийн сайд
4	Уул, уурхайн алба	Уул, уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Уул уурхайн сайд
5	Хүн ам, нийгмийн хамгааллын алба	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
6	Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
7	Түлш, эрчим хүчний алба	Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Эрчим хүчний сайд
8	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Эрүүл мэнд, спортын сайд
9	Мэдээлэл, харилцаа холбооны алба	Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга
10	Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба	Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга
11	Хэв журам сахиулах алба	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	Цагдаагийн ерөнхий газрын дарга
12	Сурталчилгааны алба		Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАДЫГ ШИНЭЧЛЭН БАЙГУУЛАХ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг уялдуулан зохицуулах зорилгоор төрийн захиргааны холбогдох байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус улсын 11 алба ажиллахаар хуульчилсан.

Хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 186 дугаар тогтоолоор Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба, Эрүүл мэндийн алба, Хүнс, хөдөө аж ахуйн алба, Түлш, эрчим хүчний алба, Зам тээврийн алба, Барилга, хот байгуулалтын алба, Мэргэжлийн хяналтын алба, Хэв журам сахиулах алба, Сурталчилгааны алба, Мэдээлэл, харилцаа, холбооны алба, Цацрагийн аюулаас хамгаалах алба, Уул уурхайн алба, Хүн ам, нийгмийн хамгааллын алба болон тэдгээрийн түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага, дарга нарыг баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 382, 387 дугаар тогтоолоор дээрх улсын албадын түшиглэн ажиллаж байсан зарим яам, агентлагийн бүтэц өөрчлөгдсөн, шинээр байгуулагдсан, татан буулгасантай холбогдуулан дээрх тогтоолд өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулав. Үүнд:

-“Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба”-ыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд,

-“Барилга, хот байгуулалтын алба”-ыг барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Барилга, хот байгуулалтын сайд,

-“Зам, тээврийн алба”-ыг зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Зам, тээврийн сайд,

-“Уул, уурхайн алба”-ыг уул, уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Уул уурхайн сайд,

-“Хүн ам, нийгмийн хамгааллын алба”-ыг хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд,

-“Хүнс, хөдөө аж ахуйн алба”-ыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Хүнс, хөдөө аж ахуйн сайд,

-“Түлш, эрчим хүчний алба”-ыг эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Эрчим хүчний сайд,

-“Эрүүл мэндийн алба”-ыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Эрүүл мэнд, спортын сайд,

-“Мэдээлэл, харилцаа холбооны алба”-ыг мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга,

-“Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба”-ыг мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

-“Хэв журам сахиулах алба”-ыг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий хууль сахиулах байгууллагыг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Цагдаагийн ерөнхий газрын дарга,

-“Сурталчилгааны алба”-ыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийг түшиглэн байгуулж улсын албаны даргаар Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга тус тус ажиллахаар тогтоолын төслийг боловсруулав.

Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоолоор Цөмийн энергийн газрыг татан буулгасантай холбогдуулан “Цацрагийн аюулаас хамгаалах алба”-ыг Гамшгаас хамгаалах улсын албадын бүрэлдэхүүнээс хасаж мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад харьяалуулан “Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба” нэртэйгээр шинэчлэн боловсруулсан болно.

Засгийн газрын 2005 оны 158 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах улсын 11 алба, 2012 оны 186 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах улсын 13 алба тус тус ажиллаж байсан бол энэхүү тогтоолын төсөлд гамшгаас хамгаалах улсын 12 алба, эдгээрт одоо мөрдөгдөж буй Засгийн газрын бүтцийн тухай хуулийн дагуу 8 яам, 3 агентлаг, олон нийтийн статустай 1 байгууллага ажиллахаар тусгав.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР